ЯАГААД БИД ХОГНЫ ТУХАЙ САНАА ЗОВИНОХ УЧИРТАЙ ВЭ?

ЭКОСУМ

Дийлэнх хог (хуванцар, зай, электрон бараа, будаг гм) **хорт бодис агуулсан** байдаг. Иймээс хог хаягдлыг хайхрамжгүй, зохисгүй хаяснаар хорт бодисууд хөрсөнд нэвчиж, бидний уудаг ундны усыг бохирдуулаг. 1950 оноос хойш дэлхий дахинд **8 тэрбум тонн хуванцар** үйлдвэрлэгдсэн бөгөөд үүний дөнгөж 9хөн хувь нь л дахин боловсруулагдсан байна.

Эх газарт үүссэн хуванцар салхинд хийсч, гол усаар дамжин далайд хүрч **асар том хогон арлуудыг хаа сайгүй** үүсгэх боллоо. Хог, тэр дундаа хуванцар эх газрын болон далайн ан амьтдад аюул учруулж байна. Хоол хүнсний гинжин хэлхээгээр дамжин **бидний тавган дээр хуванцар** ирэх нь элбэг боллоо.

Үүнээс гадна **хог хаягдал нь агаарын чанарт ихээр нөлөөлдөг.** Бидний бодсоны эсрэгээр, хог шатаах нь газарт булснаас илүү хор ялгаруулдаг байна. Хог шатаахад цаг уурын өөрчлөлтөнд нөлөөлөгч хүлэмжийн хийг үйлдвэрлээд зогсохгүй хогонд агуулагддаг хорт бодисууд задарснаар **бүр ч илүү хортой молекулуудыг үүсгэдэг** болохыг нотложээ. Диоксин болон фуран ингэж үүсдэг бөгөөд эрдэмтдийн үзэж байгаагаар эдгээр нь хамгийн хортой нэгдлүүд гэнэ.

Мөн түүнчлэн хог шатаахад үүсдэг бүх утаа, хий нь **хүний эрүүл мэндэд асар хор хөнөөлтэй** тул бид хог шатаахаа зогсоож, цаашдаа тогтвортой, аюулгүй аргаар хогноосоо салах шаардлагатай байна.

БИДНИЙ ГАРГАДАГ НИЙТ ХОГНЫ ДИЙЛЭНХ НЬ ДАХИН БОЛОВСРУУЛАГДДАГ ГЭДГИЙГ ТА МЭДЭХ ҮҮ?

ЭКОСУМ

Дахин боловсруулсан **хуванцараар** шинэ хуванцар сав, баглаа боодлын материал, хувцас болон бусад олон төрлийн зүйлийг хийж болно. Жишээ нь 27 хуванцар саваар нэг гадуур цамц хийж болдог байна. 1,000кг хуванцар ангилснаар 700кг түүхий нефт хэмнэх боломжтой.

x27 =

Металыг хэд ч дахин боловсруулж олон төрлийн эд зүйлс үйлдвэрлэх боломжтой. 190 000 ширхэг хөнгөн цагаан лаазаар нэг машин босгох боломжтой бол уулын унадаг дугуйнд ердөө 670 ширхэг лааз л хангалттай байдаг гэнэ.

x670 =



1 тн

17 мод

аварна

Цаас болон картон цаасыг дахин боловсруулж шинэ цаас, ариун цэврийн цаас, өндөгний хайрцаг зэргийг хийж болдог. 1,000кг хаягдал цааснаас бид 900кг дахин боловсруулсан цаас гаргаж авч чадах бөгөөд ингэснээр 17 ширхэг мод хэмнэнэ гэсэн үг юм.

Бөс даавууны хаягдлаар шинэ хувцас хийж дахин боловсруулдаг. Монголын нөхцөлд бол бид хуучин хувцас, эдлэлээр малын нэмнээ хийж ашиглах бүрэн боломжтой.

Шилээр шинэ савнууд (лонх, жижиг шилэн сав гм)-ыг үйлдвэрлэдэг төдийгүй барилгын ажилд ч (цемент, дүүргэлт гм) багагүй ашигладаг байна. Earth-ship загварын барилгуудад шилэн лонхнуудыг тоосгоны оронд хэрэглэх нь элбэг.

Органик хаягдал буюу ногооны хальс, цай кофены шаар болон өндөгний хальсаар ялзмаг хийснээр тариаланчдад нэн чухал байгалийн гаралтай маш сайн бордоо болдог.

Зай, электрон бараа, модны хаягдал, машины дугуй... бараг бүх төрлийн хаягдлыг ямар нэг аргаар боловсруулах боломжтой болжээ. Бидний модны үнс хүртэл дахин ашиглагдах боломжтой. Газар тариаланд бордоо, шавьжны эсрэг хэрэглэдэг бол гэрийн нөхцөлд хувцас болон аяга таваг угаах саван гаргаж авдаг.

ХОГ ХАЯГДЛЫГ ДАХИН БОЛОВСРУУЛАХАД НЭГ Л ЗҮЙЛ ХАМГИЙН **ЧУХАЛ:** ТЭДНИЙГ ЭХЛЭЭД АНГИЛСАН БАЙХ ШААРДЛАГАТАЙ

ЭКОСУМ

Төрөл бүрийн хог нэгэнт холилдсон нөхцөлд **дараа нь ангилж боловсруулахад маш хүндрэлтэй** болдог. Ялангуяа хөрсөнд булагдаж эсвэл аюултай бодистой холилдсон бол. Ийм учраас л бүх төрлийн хаягдлыг эх үүсвэр дээр нь **ангилах нь маш чухал** бөгөөд хог болохоос нь өмнө нөөц болгох шаардлагатай юм.

Үнэндээ ангилах нь үнэхээр амархан! Өөрсдийн байнгын зуршлаа багахан өөрчлөөд **нэг хогийн савны оронд хэд хэдэн** савтай байхад л хангалттай юм. Танайд тэртэй тэргүй байгаа гялгар уутыг хэрэглэж болно, эсвэл бид танд хогоо ангилах савтай болоход тусалж ч болно. Ангилаад эхлэхээрээ та харах болно, их сонирхолтой, бүр сорилт тоглоом болдог!

ХУВАНЦАР
ундааны сав, гялгар уут,баглаа боодол

ШИЛ
архины болон бусад шилэн сав...

ЦААС / КАРТОН
сүүний сав мөн орно

МЕТАЛ
лааз, газны сав, бусад...

ХУВЦАС, ДААВУУ
хуучин гутал, хувцас, даавуу

ОРГАНИК
ногоо, өндөгний хальс, цайны шаар гм

МОД, АРГАЛЫН ҮНС
нүүрсний үнстэй холихгүй

БУСАД...
зай, электрон бараа, эвдэрсэн эд зүйлс

Ирэх хавар бид Хишиг-Өндөр суманд **хог хаягдлыг зохистой зохицуулах,** бидний шаардлагад нийцсэн цэгийг барьж байгуулах болно. Энэ цэг маань бэлэн болоход та зөвхөн өөрийн **ангилсан хогийг авчирахад** л хангалттай бөгөөд үлдсэн бусад асуудлуудыг бид хариуцан шийдэх болно.

Харин энэ хооронд та одооноос хогоо ангилж эхлэх бүрэн боломжтой бөгөөд **Экосум-ын төв оффист** авчирч өгөх боломжтой. Хог зохицуулах цэг маань бэлэн болтол бид эндээ хүлээн авч зохицуулахаар шийдсэн байгаа. Хэрэв танд ямар нэг асуулт гарвал **бид хэзээд танд туслахад бэлэн** байх болно.

БАС НЭГЭН ЗӨВЛӨГӨӨ: ХАМГИЙН ХОРГҮЙ ХОГ БОЛ БАЙХГҮЙ БАЙГАА ХОГ ЮМ!

ЭКОСУМ

Дахин боловсруулах нь олон гайхалтай боломжуудыг олгож, асар их байгалийн баялагийг хэмнэдэг давуу талтай. Гэвч бид хог хаягдлаа бүр 100% дахин боловсруулдаг болсон ч дахин боловсруулах үйл явцад **ус, цахилгаан, олон төрлийн химийн бодисууд шаардагддаг.** Тэгэхээр дахин боловсруулах нь ч байгальд учруулах хор нөлөөтэй гэсэн үг юм.

Ийм учраас л бүр анхнаасаа **хог үүсгэхээс зайлсхийх** нь хамгийн шилдэг арга зам юм. Үүнийг маш олон төрлөөр гүйцэлдүүлэх боломжтой: хуванцар баглаа боодолгүй эсвэл маш бага баглаа боодолтой бүтээгдэхүүнүүдийн сонгон худалдаж авах гэх мэт. Мэдээж дээр нь **нэг удаагийн хэрэглээний бүтээгдэхүүн хэрэглэхээ бүрэн зогсоох!**

Нэг удаагийн хуванцар уут болон аяганууд аюулгүй мэт харагдавч тэднийг үйлдвэрлэхэд **их хэмжээний байгалийн баялаг, эрчим хүч, цаг хугацаа ордог** нь эргээд байгаль орчинд асар их хор хөнөөлийг авчирч байдаг. Сайтар тунгаагаад үзвэл **хэдхэн секунд, минут хэрэглээд хаяхын төлөө** тэднийг хэрэглэх нь угаас утгагүй зүйл биш гэж үү?!

ЭЦЭСТ НЬ УРИАЛАХАД, ХОГ ХАЯГДЛЫН ТУХАЙД ДАРААХ 3 ЗАРЧМЫГ БАРИМТАЛЦГААЯ: БУУРУУЛЪЯ, ДАХИН ХЭРЭГЛЭЭ, ДАХИН БОЛОВСРУУЛЪЯ.

1. Бууруулах: Хамгийн түрүүнд өөрийн гаргаж байгаа хог хаягдлаа тэднийг үүсгэдэг хэрэглээгээ багасгаж бууруулахыг хичээх. Үүний тулд шаардлагагүй зүйлийг анхаас нь худалдаж авахгүй байх эсвэл зөвхөн тогтвортой хөгжил, байгаль орчин болон ёс зүйн шаардлага хангасан бүтээгдэхүүнийг л худалдаж авах.

2. Дахин хэрэглэх: Дараагийн алхам нь таны худалдан авч буй бүтээгдэхүүн дахин хэрэглэгдэх боломжтой эсэхийг байнга нягтлах. Та нэг удаагийн гялгар уут, хуванцар сав, аяга гэх мэтийг дахин хэрэглэгддэг бүтээгдэхүүнүүдээр солиорой. Эвдэрсэн зүйлсийг шууд хаяж, шинээр солихын оронд засч сэлбэх, өөр зорилгоор хэрэглэх гэх мэт боломжит хувилбаруудыг хайгаарай.

3. Дахин боловсруулах: Хэрэв эхний 2 шатыг хэрэгжүүлэх боломжгүй учир та ямар нэг эд зүйлээ хаях шаардлагатай бол сүүлийн шат нь энэ зүйл эцсийн хог болж хогийн цэг дээр хаягдахаас сэргийлэн дахин боловсруулах үйл явцад зайлшгүй очих боломжийг бүрдүүлэх зорилготой юм. Органик хаягдлаар бордоо хийх эсвэл амьтдын хоол хүнсэнд хэрэглэх нь мөн л дахин боловсруулж байгаа нэг хэлбэр юм.

Дэлгэрэнгүй тайлбарыг дараах бичлэгээс үзнэ үү www.ecosoum.org/hog